

**УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН ДАХЬ
ХҮҮХДИЙН ӨВЧНИЙГ ОНОШЛОХ АРГЫГ
ТОДРУУЛАХ НЬ**

*Т.Туруунаа¹, Х.Улаан-Од², Х.Ууганжаргал³ Ш.Болд⁴
1,2“Ач” АУИС, 3, 4ЭЗШУИС*

**IDENTIFYING DIAGNOSTIC METHOD OF PEDIATRIC IN
TRADITIONAL MEDICINE**

*Turuunaa.T¹, Ulaan-Od. KH², Uuganjargal.KH³, Bold.Sh²
1“Ach” Medical University
2University of Pharmaceutical Sciences*

Abstract

Background: “The Oral Instruction Tantra” of “Four Medical Tantras” divides diseases in children into 4 parts: causes, condition, categories and symptoms. The diseases are proven with inquiries and examination by touching and looking. The most interesting type of examination is considered to be touching, which the main part is pulse-feeling. However, pulse feeling of children in traditional medicine is different from that of adults.

Methods: Document analysis, logical argumentation, analytic-synthetic distinction, grouping and content analysis were used on studying traditional medical books, research literature and other related materials.

Results: The general diagnostic method of traditional medicine consists of 3 parts: inquiry, pulse diagnosis and analyzing patient’s urine. The diagnostic method in pediatrics in traditional medicine is based on the general method but different in some ways in consistence with the classification of diseases in children (Four Medical Tantras).

Conclusion: The conclusion from the research results are as follows:

1. Inquire the symptoms of children from parents and examine the children’s faces
2. Research the method of examining ear veins, identify its scientific nature and open up possibility to use it in training
3. Define the content and characteristics of methods of examining hot and cold quality of child’s ear by touching, and checking color and shape of veins and include these in curriculum of universities that offers traditional medicine program

Key words: Pediatrics, Examining ear veins, diagnostic method, boldshrv@gmail.com

Үндэслэл

Уламжлалт анагаах ухааны оношилгооны ерөнхий арга нь гурван хэсгээс бүрдэнэ. Эхнийх нь асуух шинжилгээ бөгөөд хоёр дахь нь өвчтөний судсыг хүрэлцэж шинжлэх, гурав дахь нь өвчтөний шээсийг үзэж шинжлэх арга юм. Харин уламжлалт анагаах ухааны нялхсын өвчнийг оношлох арга нь оношилгооны ерөнхий аргад тулгуурлахаас гадна хүүхэд (Шүнгийн номонд нялхас гэдэг [1])-ийн өвчний ангилалд тулгуурлан зарим талаараа ялгаатай байдаг.

“Анагаах ухааны дөрвөн үндэс”-ийн “Увдисын үндэс” [2]-т Нялхсын өвчнийг шалтгаан, нөхцөл, ангилал, шинж тэмдэг хийгээд засах арга гэсэн 4 хэсэгт хуваан үзүүлдэг. Хүүхдийн өвчний шалтгаан нь хий, шар, бадган гурав юм. Нөхцлийг эхийн болон хүүгийн нөхцөл гэж 2 зүйлд хуваана. Эхийн нөхцөл нь эхийн идээ, явдал мөрийн аль нэг нь аривдсанаар хий шар бадганы бэлгэ чанар арвидан улмаар эхийн хий, шар, цус, бадганы алины язгуур хүүд унаж, ариун бус адын нөхцлөөр дүлий, хэлгий, тахир, бөгтөр, сохор, сэтэрхий уруултай зэрэг эмгэгтэй төрдөг. Эдгээр нь хамт төрсөн өвчин мөн тул анагаах чадахгүй хэмээнэ. Нөгөө талаар хүүгийн нөхцөлд ад, явдал мөр, идээ гурав багтана. Адын нөхцөл олон ч нялхсын ад 12 байдаг. Явдал мөр гэдэгт эх болон хүүхдийн асрагч нар асаргаа сувилгааг зохистой хийгээгүйн улмаас хүүхэд унах, цохигдох, сэгсрэгдэх, хүйс татагдах, хэтэрхий уйлах, хэт их чийг авах, идээ ундааг хэт халуун эсвэл хэт сэрүүн шүтсэнээр нялхсын 24 язгуур өвчнийг үүсгэнэ. Эдгээр өвчнийг асуух, хүрэлцэх, үзэх шинжилгээгээр нотлоно. Эдгээр шинжилгээнээс хүрэлцэх шинжилгээний арга ихээхэн сонирхол татдаг. Хүрэлцэх шинжилгээний үндсэн арга нь судас үзэх арга юм. Гэхдээ уламжлалт анагаах ухааны тогтолцоонд хүүхдийн судсыг барих арга нь насанд хүрэгсдийн судсыг барихаас өөр байдаг.

Хүүхдийг шинжлэх болон оношлох арга

Шинжлэх гэдэг нь харьцангуй эрүүл хүүхдийг, оношлох нь өвчтэй хүүхдийн өвчний оношийг тогтоох аргыг зааж буй.

Төвөд анагаах ухаанд хүүхдийн шинжлэх гурван янзын арга байдаг [3].

Үүнд:

1. Юуны өмнө нь хүүхдийн чих болон чихний ар хэсгийг үзнэ.

2. Хоёр дахь нь хүүхэд өвдсөн үедээ хэрхэн уйлж байгаагаар нь оношлоно. Учир нь хэлд ороогүй нялх хүүхэд ярихгүй, биеийнх нь аль хэсэгт өвдөж байгаагаа зааж илэрхийлж чадахгүй. Тиймээс уйлах дуу нь оношилгооны ач холбогдолтой юм.
3. Гурав дахь арга нь хөхүүл ээжийн сүүг шинжлэх арга. Сүүг усанд дусааж шинжлэнэ.

Хүүхдийг асууж шинжлэх арга нь эх, эцэг, асран хамгаалагч нараас нарийн тодорхой асуухад тулгаарлана.

Үзэх шинжилгээний хүрээнд хүүхдийн цог жавхлан, өнгө зүс, ухаан мэдрэл, тамир тэнхээ, таван эрхтэнд илрэх хувиралт, хүүхдийн хурууны судас, чихний арын судсыг шинжлэх аргууд багтана. Мөн хүүхдийн хэвлийн ханыг тэмтэрч үзэх, бугуйн судсыг тэмтэрч судасны цохилт, тоог тодруулна.

Хүүхдийн чихийг шинжлэх арга

Хүүхдийн чихний судсыг шинжлэх нь хүүхдийн өвчнийг оношлоход чухал үүрэгтэй байдаг. Тиймээс өвчилсөн үед хүүхдийг чихний судасны өнгө, хэлбэр, байдлыг ялган таних нь их чухал юм. Тухайлбал чихний судасны байдал болон түүний халуун, хүйтнийг хүрэлцэж шинжлэхээс гадна чихний судасны өнгийг гол болгон шинжлэнэ.

Хүүхдийг нарны гэрлийн эсрэг суулгаад эмч шинжлэх хүүхдийнхээ ард зогсоно. Чихний дэлбэнг хоёр гараараа барьж толгойн эсрэг татаж чихний ар талыг гэрэлд харна. Хэрэв өрөөнд нарны гэрэлгүй бол хүүхдийн чихийг урд талаас нь гэрэлтүүлж үзнэ. Үзэхдээ чихний намжуун (вен) судсыг шинжлэнэ.

Эрүүл хүүхдийн чихний халуун, хүйтэн нь тэгш буюу бүлээн, судасны бүдүүн нарийн нь ч тэгш байдаг. Жишээлбэл: Улаан торгон утсыг татсан юм шиг жигд, судсууд нь мушгираагүй, тасраагүй, хоорондоо давхарлаж наалдаагүй, салбарлаагүй, бүдэг бус, судасны дээр нь хар, цагаан, улаан толбо үзэгдэхгүй, үлгэрлэвээс: Гүйлс модны навчны арын зураас дэлгэрсэн мэт оршиж байваас эрүүлийн шинж гэж мэднэ.

Чихний судаснаас гурван гол судсыг ялган шинжилнэ. Шинжлэхдээ баруун чихний хамгийн дээд талын намжуун судас нь уушги, олгойн үйлийг заадаг. Дунд талын намжуун судас нь элэг, цөсний судсыг, доод талын намжуун судас нь баруун бөөр, давсагны үйлийг тус тус заадаг. Дараа нь хүүхдийн зүүн чихийг шинжлэнэ. Зүүн чихний хамгийн дээд талын намжуун судас нь зүрх, гэдэсний, дунд намжуун судас нь дэлүү, ходоодны, доод талын намжуун судас нь зүүн бөөр, эмэгтэй хүүхдийн умай, өндгөвчийг, эрэгтэй хүүхдийн гадна, дотно бэлгэ эрхтэний үйлийг заадаг (Хүснэгт 1) [4].


Хүснэгт 1. Чихэн дээрх 5 цул, 6 савын байрлал

№	Эрхтэн	Байрлал	5 цул, 6 сав
1	Зүүн чих	Дээд хэсэг	Зүрх, гэдэс
2		Дунд хэсэг	Дэлүү, ходоод
3		Доод хэсэг	Зүүн бөөр, самс
4	Баруун чих	Дээд хэсэг	Уушги, олгой
5		Дунд хэсэг	Элэг, цөс
6		Доод хэсэг	Баруун бөөр, давсаг

Хэрвээ эрүүл төлөв байдал өөрчлөгдөж бүдүүн, нарийн нь тэгш үгүй, судасны өнгө нь хоорондоо адил бус болсон байвал ямар нэгэн өвчтэй болсны шинж хэмээн тооцно. Хүүхэд өвчилсэн үед эхлээд хоёр чихний намжуун судасны өнгийг шинжилнэ. Баруун чихний намжуун судас нь биеийн баруун талын эрхтний өвчний байдлыг, зүүн чихний намжуун судас нь биеийн зүүн талын эрхтний үйлийг заана.

Эхлээд судасны өнгийг шинжлэхдээ судас бүдүүрсэн эсэх, өнгө нь хувирсан эсэхийг шинжлэх бөгөөд энэхүү үзэгдэл нь аль цул, савын оронд илэрч буйг 5 махбодтой уялдуулан шинжлэнэ.

Намжуун судсыг үзэх үед өнгө нь хүрэн эсвэл хар байх нь хүүхэд халуунтайн шинж юм. Халуурч байгаа тохиолдолд биеийн температурыг шалгана. Уламжлалт анагаах ухааны онолын ёсоор бол халууралт нь ихэнхдээ зүрх болон элэгний шарын язгуураас үүссэн байдаг. Хүүхдийн халууралтын эхний шинж тэмдэг нь хүүхдийн духнаас эхэлдэг. Өөрөөр хэлбэл уламжлалт анагаах ухааны онолоор бүх биеийн халууралт нь духнаас эхэлнэ гэсэн үг юм (зураг 1¹).



Зураг 1. Халууралт эхэлдэг духны хэсэг:
хос мөнгөн багана судас, голд нь алтан багана

Зүрхний судсыг шинжлэх:

Зүрхний судасны өнгө нь улаан бол сайн гэж үзнэ. Хар бол өвчин нь хүнд буйн шинж болно. Хөх бол элгэнд халуун байгаан шинж. Шар бол ходоод гэмтэй, цагаан бол уушгинд халуун байх буюу хий, халуун байхын шинж болно.

Элэгний судсыг шинжлэх:

Элэгний судасны өнгө нь хөх бол хэвийн бөгөөд цагаан бол өвчний байдал хүнд, эвэршээл их буйн шинж юм. Шар бол шараас болсон өвчний шинж. Улаан бол аль нэгэн цүлд халуунтайн шинж. Харин аар бол элгэнд цусан халуун буюу элэгний цусан халуун ходоодонд буусны шинж болно.

Баруун бөөрний судсыг шинжлэх:

Баруун бөөрний судасны өнгө нь бор бол өвчтөнд ямар нэгэн өвчний шинж тэмдэггүйн байдал юм. Улаан бол зүрхэнд халуунтай бөгөөд ямар нэгэн сав эрхтэнд сэрүүн байхын шинж. Шар бол бөөлжиж, суулгах өвчин болохын, цагаан бол эхийн сүү буюу ямар нэгэн идээ харшилдсанаас шалтгаалсан өвчний, харин хөх бол ханиад буюу салхин өвчний шинж болно.

Уушгины судсыг шинжлэх:

Уушгины судасны өнгө нь цагаан бол сайн бөгөөд ямар нэгэн хүндрэл байхгүйн шинж тэмдэг. Улаан бол түргэн чанартай ханиад буюу салхин өвчний шинж, шар бол ходоод доргисон гэмийн, хөх бол үе гишүүний гэм буй. Хар бол халуун ихтэйн шинж болно.

Дэлүүний судсыг шинжлэх:

Дэлүүний судлын өнгө нь шар бол сайн байдаг. Хөх бол муу бөгөөд өвчин хүндрэх аюултай. Улаан бол нуугдсан халууны шинж. Цагаан өнгө нь даарснаас болсон өвчний шинж. Хар бол ямар нэгэн юмнаас айж цочсоноос (ад) болсон өвчний шинж юм.

Зүүн бөөрний судсыг шинжлэх

Зүүн бөөрний судасны өнгө нь бор бол өвчний байдал хөнгөн байгаан шинж. Улаан бол нарийн гэдсэнд гэмтэй байхын шинж. Хөх бол айж цочсоны гэмээс шалтгаалсан өвчний шинж. Цагаан бол хүйтэн идээ ундаанаас болсон өвчний, шар бол удаан чанартай тахал өвчний шинж юм (Хүснэгт 2) [5].

Үүнээс гадна хүүхдийн чихний судас нь өөрийн орноос шилжиж муруйх буюу тасрах зэрэг шинжүүд илэрвэл өвчний байдал хүнд байхын шинж болно.

**Хүснэгт 2. Хүүхдийн чихний судасны өнгийг
5 махбодтой уялдуулан шинжлэх нь**

Судлын ялгал		Зүрхний судас	Элэгний судас	Баруун бөөрний судас	Уушгины судас	Дэлүүний судас	Зүүн бөөрний судас
Гал	Улаан	Сайн	Цулд халуунтай	Зүрхэнд халуунтай	Цочмог дагшуур өвчин	Нуугдсан халуун	Гэдсэнд гэмтэй
Ус	Хар	Өвчин хүнд	Элэг, ходоод гэмтэй	Сайн	Халуун ихтэй	Айж цочсоны гэм	Сайн
Мод	Хөх	Элэгний халуун	Сайн	Ханиад, салхин өвчин	Үе гишүүний өвчин	Өвчин хүнд	Айж цочсон (Ад)
Шороо	Шар	Ходоод өвчинтэй	Шарын өвчин	Бөөлжиж, суулгах өвчин	Ходоод доргисон	Сайн	Тахал өвчин
Төмөр	Цагаан	Уушгины хий өвчин	Өвчин хүнд	Идээ, ундааны гэм	Сайн	Хүйтний гэм	Идээнээс гэмтсэн

Намжуун судасны хүйтний шинж тэмдэг нь маш цайвар өнгөтэй болдог. Цайвар өнгө нь ихэнхдээ цагаан эсвэл цагаан шар өнгөтэй байдаг. Ходоод болон хоол боловсруулах эрхтэний өөрчлөлттэй үед хүйтэн нь хүүхдийн биеийн доод хэсэгт мэдрэгдэнэ. Намжуун судас нь цайвар улаавтар өнгөтэй байх нь цусны шалтгаантай байх ба ихэнхдээ маш цайвар, цайвар шар өнгөтэй болно. Энэ нь хүйтэн өвчин болно.

Цусны өнгө нь маш цайвар цаас шиг цагаан байх нь цэр ихтэй байгааг заадаг. Түүнчлэн энэ шинж нь хүүхэд ямар нэгэн юм идэх үед бөөлжих, гулгих шинж тэмдэгтэй хамт илэрч болно. Мөн хүүхдийн ходоод нь дүүрсэн байдаг. Хүүхэд салхин цэцэгтэй үед чихний судас улаавтар болохыг зэрэгцээ чих нь улаавтар өнгөтэй болно. Нүдийг шалгахад нүдний цагаан нь улаан намжуун судастай болж, нүд нь тод болно. Салхин цэцэг нь нэн даруй үүсвэл хүүхэд эмгүйгээр маш хурдан эргэн сэргэж илааршина гэж үздэг. Даруй үүсэхгүй бол хүүхдэд эмийн эмчилгээ хэрэгтэй. Хоёр чихний намжуун судас нь хар өнгөтэй байвал хүүхэд гадаад орчны сөрөг нөлөөнд (адын шинжтэй) байгааг заадаг. Хүүхдийн чихний судсыг гэрэлд харах үед намжуун судас байхгүй байх нь архаг өвчинг, бүдэг бол хүүхдийн амьдрал аюултай байгааг заадаг.

Уламжлалт анагаах ухааны оношилгооны ерөнхий арга нь гурван хэсгээс бүрдэнэ. Эхнийх нь асуух шинжилгээ бөгөөд хоёр дахь нь өвчтөний судсыг хүрэлцэж шинжлэх, гурав дахь нь өвчтөний шээсийг үзэж шинжлэх арга юм. Харин уламжлалт анагаах ухааны хүүхдийн өвчнийг оношлох арга нь оношилгооны ерөнхий аргад тулгуурлахаас гадна хүүхэд (Шүнгийн номонд нялхас гэдэг)-ийн өвчний ангилалд тулгуурлан зарим талаараа ялгаатай байдаг.

Судалгааны ажлын үр дүнгээс гарсан дүгнэлтыг дараах байдлаар илэрхийлж байна. Үүнд:

1. Хүүхдийн өвчний шинж тэмдгийг эцэг, эхээс нь нягтлан асуух, нүүр царайны өнгийг шинжлэх;

2. Чихний судсаар шинжлэх аргыг судалгааны эргэлтэд оруулах, цаашид гүнзгийрүүлэн судлах, шинжлэх ухааны мөн чанарыг тогтоох, сургалтад ашиглах боломжийг нээх;

3. Дээрх аргуудаас хүүхдийн чихний халуун, хүйтнийг хүрэлцэж шинжлэх, чихний судасны өнгийг шинжлэх, хэлбэрийг шинжлэх аргын агуулга, онцлогийг тус бүрээр нь тогтоон уламжлалт анагаах ухааны их эмч бэлтгэдэг сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах нь чухал болсоор байна.

Ном зүй

1. བདུད་ཅི་ལྷིང་པོ་ཡན་ལག་བརྒྱད་པ་གསང་བ་མན་ངག་གི་རྒྱུད། Модон барын төвөд
судар

2. བདུད་ཅི་ལྷིང་པོ་ཡན་ལག་བརྒྱད་པ་གསང་བ་མན་ངག་གི་རྒྱུད། Модон барын төвөд
судар

3. Lady doctor Lobsang Dolma Khangkar. Lecture on Tibetan Medicine. New Delhi, 1986

4. Намжил, Багана. Монгол анагаах ухааны мод тавих ёс хийгээд нууц гарын авлагын тайлбар. ӨМӨЗО, СХХХ, 1994

5. Намжил, Багана. Монгол анагаах ухааны мод тавих ёс хийгээд нууц гарын авлагын тайлбар. ӨМӨЗО, СХХХ, 1994

Танилцаж нийтлэх санал өгсөн:

Академич Л.Хүрэлбаатар